



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 04 дүгээр сарын 15  
№14 /1212/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Хуульчилсан  
Мэдээлэл

Хуульчилсан  
Мэдээлэл

Хуульчилсан  
Мэдээлэл



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

241.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 108	1078
242.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 109	1078
243.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 110	1079
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
244.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 210	1079

## ЗАНГАГА

7᠘᠐᠖	᠖᠒᠐	ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠭᠡᠨᠯᠡᠭᠴᠢᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ	᠒᠐᠒᠐
7᠘᠐᠖	᠐᠒᠐᠐	ᠶ᠋ᠢᠨᠭᠡᠨᠯᠡᠭᠴᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠭᠡᠨᠯᠡᠭᠴᠢᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ	᠒᠐᠒᠐
᠗᠘᠐᠖	᠐᠖᠖	ᠶ᠋ᠢᠨᠭᠡᠨᠯᠡᠭᠴᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠭᠡᠨᠯᠡᠭᠴᠢᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ	᠒᠐᠒᠐
᠗᠘᠐᠖	᠐᠖᠓	ᠶ᠋ᠢᠨᠭᠡᠨᠯᠡᠭᠴᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠭᠡᠨᠯᠡᠭᠴᠢᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ	᠒᠐᠒᠐



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, мөн зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2021 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Цэвээнддоогийн Өрнөндэлгэрийг Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас, Шарын Оюунгэрэлийг Сүхбаатар аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2021 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Дагаагийн Байгалмааг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.1 дэх заалт, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2021 оны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүгчийн албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан Сэргэлэнгийн Энхбаярыг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 7 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 210

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Өрийн удирдлагын тухай хуулийн 35.6, 35.10-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулах журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээний загвар”-ыг 2 дугаар хавсралт, “Засгийн газрын өрийн баталгааны авлага барагдуулах гэрээний загвар”-ыг 3 дугаар хавсралт, “Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагчийн төлөх шимтгэлийн дүнг тооцох аргачлал”-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 146 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**САНГИЙН САЙД**

**Б.ЖАВХЛАН**

Засгийн газрын 2021 оны 210 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГААНЫ ДАГУУ  
БАЙГУУЛАХ ГЭРЭЭ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА,  
АВЛАГА БАРАГДУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Засгийн газрын өрийн баталгаа гаргахад тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, баталгаажуулах, Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2.Засгийн газрын өрийн баталгаа гаргахад Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3.Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Засгийн газрын өрийн баталгаа” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.7-д заасныг;

1.3.2.“баталгаа гаргуулагч” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 34.1-д заасан этгээдийг;

1.3.3.“баталгаа гаргагч” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.7-д заасан үүргийг хүлээсэн этгээдийг;

1.3.4.“зээллэг болон өрийн баталгааны дээд хэмжээ” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.14-т заасныг;

1.3.5.“төсөл, арга хэмжээ” гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.23-т заасныг;

1.3.6.“төсөл, арга хэмжээний өгөөж” гэж Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний мөнгөн хөрөнгийн суурь төсөөллөөр тооцоологдсон төслийн дотоод үр өгөөж (Internal Rate of Return), цэвэр өнөөгийн үнэ цэнэ (Net Present Value), зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх хугацаа (Payback period) болон бусад санхүүгийн үзүүлэлтүүдийг.

1.4.Засгийн газрын өрийн баталгаа гаргахад Өрийн удирдлагын тухай хуулийн 5.1-д заасан зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:

1.4.1.Засгийн газар зөвхөн өөрийн гаргасан баталгааны хүрээнд үүсэх эрсдэлийг үүрэх;

1.4.2.зөвхөн эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээ, санхүүгийн чадавхтай, үйл ажиллагааны аливаа эрсдэлийн даатгалд хамрагдсан баталгаа гаргуулагчид Засгийн газрын өрийн баталгаа гаргах.

Хоёр.Засгийн газрын өрийн баталгаа гаргахад тавигдах шаардлага

2.1.Засгийн газрын гаргах өрийн баталгаа нь Өрийн удирдлагын тухай хуулийн 33.2-т заасан шаардлагыг хангасан байна.

2.2.Засгийн газрын өрийн баталгаа гаргах зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 33.3 болон 33.8-д заасан шаардлагыг хангасан байна.

2.3.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч нь Өрийн удирдлагын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

2.3.1.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, үнэт цаас гаргахдаа удирдлагын хариуцлагын даатгал, зээлдэгчийн амь насны даатгалд даатгуулсан байх;

2.3.2.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах зээллэгийн хөрөнгийг төсөл, арга хэмжээний ирээдүйд үүсэх орлогоос эргэн төлөх тохиолдолд зээллэгийн гэрээнд үндсэн зээлдэгчээс гадна төслийн орлогоос хувь хүртэгч бусад байгууллагын санхүүгийн эрх, үүрэг хариуцлагыг тусгаж, талууд үзэглэсэн, эсхүл энэ талаар төсөлд оролцогч талууд хооронд тохиролцсон гэрээ, эсхүл батлан даалтын гэрээ байгуулсан байна.

Гурав.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлт гаргах

3.1.Энэ журмын 2.3-т заасан шаардлагуудыг хангасан баталгаа гаргуулагч нь энэ журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээнд баталгаа гаргуулах тухай хүсэлтээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараахь баримт бичгийн хамт хүргүүлнэ:

3.1.1.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах зээллэгийн нөхцөлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түүний зориулалт, зээллэгийн гэрээ, тухайн зээллэгийг эргэн төлөх төлөвлөгөө;

3.1.2.аудитаар баталгаажсан сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт;

3.1.3.хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотолсон тодорхойлолт;

3.1.4.төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран баталгаажсан зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ;

3.1.5.баталгаа гаргуулагчийн талаарх хөндлөнгийн байгууллагын хууль зүйн болон санхүүгийн дүгнэлт;

3.1.6.олон улсын болон дотоодын хөндлөнгийн байгууллагаас гаргасан баталгаа гаргуулагчийн хийх зээллэгт учирч болох эрсдэлийн эсхүл зээлжих зэрэглэлийн дүгнэлт;

3.1.7.баталгаа гаргуулагч нь дотоодын арилжааны банк бол дараахь мэдээллийг агуулсан Монголбанкны албан бичиг:

3.1.7.1.тухайн банкны сүүлийн гурван жилийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт;

3.1.7.2.Монголбанкнаас санхүүгийн дэмжлэг, зээл олгосон эсэх, тийм бол түүний хэмжээ, хугацаа, хэрэгжилтийн байдал;

3.1.7.3.тухайн банкинд Монголбанкнаас сүүлийн 3 жилд хийсэн хяналт, шалгалтын тайлан.

3.2.Энэ журмын 3.1.5-д заасан хууль зүйн хөндлөнгийн дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд хууль зүйн магадлан шинжилгээ (Due Diligence) хийсний үндсэн дээр дор дурдсан асуудлаар дүгнэлт гаргана:

3.2.1.баталгаа гаргуулагч хуулийн этгээд нь Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, эцсийн өмчлөгч эсэх;

3.2.2. баталгаа гаргуулагч хуулийн этгээдийн дүрэм, зээлийн бодлогын баримт бичиг, засаглалын журмууд нь Монгол Улсын хууль тогтоомж, засаглалын кодекст нийцэж буй эсэх;

3.2.3. баталгаа гаргуулагч хуулийн этгээд нь хуулийн этгээдийн нэгдэлд хамаарч буй бол нэгдлийн бүтэц, зээлдүүлэгч байгууллага нь баталгаа гаргуулагчтай нэгдмэл сонирхолгүй, хамааралгүй этгээд байх шаардлагыг хангаж байгаа эсэх;

3.2.4. сүүлийн гурван жилийн хугацаанд хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь хуульд нийцсэн эсэх, хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх;

3.2.5. баталгаа гаргуулагч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтнууд нь уг төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг туршлагатай эсэх, авлига, албан тушаал, Мөнгө угаах, терроризмтай тэмцэх тухай хуульд заасан зөрчил гаргаж, хуулийн хариуцлага хүлээж байсан эсэх;

3.2.6. баталгаа гаргуулагч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд голлох нөлөө бүхий хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр тохиролцсон зээлийн, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан болон энэ журмын 2.3.1-д заасан даатгал, 2.3.2-т заасан гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн, хүчин төгөлдөр эсэх, гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн байдал;

3.2.7. баталгаа гаргуулагч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхэлдэг бол тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх, тусгай зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөний улмаас сүүлийн нэг жилийн хугацаанд эрх бүхий байгууллагын зүгээс хуулийн хариуцлага хүлээлгэж байсан эсэх;

3.2.8. төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц шүүх, арбитрын шийдвэр, хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, эсхүл шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх;

3.2.9. Засгийн газрын үнэт цаасаар баталгаажсан буюу барьцаалсан баталгаа гаргуулах тохиолдолд тухайн үнэт цаасыг бусдад барьцаалуулах зэргээр үүргийн гүйцэтгэл хангуулах аливаа үүрэг хүлээсэн эсэх;

3.2.10. татвар, нийгмийн даатгалын өртэй эсэх;



3.2.11. татан буугдах нөхцөл үүссэн эсэх, татан буулгах ажиллагаа явагдаж байгаа эсэх.

3.3. Энэ журмын 3.1.5-д заасан санхүүгийн хөндлөнгийн дүгнэлтийг санхүүгийн шинжилгээ хийх ур чадвар, туршлага бүхий этгээд дараахь төрлийн шинжилгээ хийсний үндсэн дээр дүгнэлт гаргасан байна:

3.3.1. төлбөрийн чадварын шинжилгээ;

3.3.2. санхүүгийн дампуурлыг урьдчилан тооцоолох шинжилгээ;

3.3.3. хөрөнгө капиталын ашиглалтын байдлын шинжилгээ;

3.3.4. ашигт ажиллагааны шинжилгээ.

3.4. Баталгаа гаргуулагчаас ирүүлсэн мэдээлэл хуульд заасны дагуу төр, хувь хүний, эсхүл албаны нууцад хамаарах тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөндлөнгийн шинжилгээ хийж, дүгнэлт хийхэд оролцож буй этгээд мэдээллийн нууцыг чандлан сахиж, олон нийтэд задруулахгүй байх үүрэгтэй.

3.5. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаа гаргуулагчаас ирүүлсэн баримт бичгийг хянаж, нэмэлт мэдээлэл, тодруулга ирүүлэхийг шаардаж болно.

3.6. Дор дурдсан үндэслэлээр Засгийн газрын өрийн баталгаа гаргах боломжгүй гэж үзсэн бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаа гаргуулах хүсэлт гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ:

3.6.1. хүсэлтийг Өрийн удирдлагын тухай хууль болон энэ журмын дагуу гаргаагүй;

3.6.2. хүсэлт гаргагч, төсөл, арга хэмжээ, гаргасан хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь тогтоосон шаардлагыг хангаагүй;

3.6.3. шаардлагатай мэдээллийг хүсэлтэд тусгаагүй, эсхүл дутуу тусгасан;

3.6.4. худал, төөрөгдүүлсэн, алдаатай, эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл тусгасан;

3.6.5. шаардлагатай нэмэлт мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлээгүй;



3.6.6.Засгийн газрын баталгаа гаргахад тавигдах шаардлага хангаагүй гэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үзсэн тохиолдолд.

Дөрөв.Эрсдэлийн үнэлгээ хийх, дүгнэлт гаргах

4.1.Өрийн баталгаа гаргуулах тухай хүсэлт нь энэ журмын 2.1-2.3, 3.1-3.3-т заасан шаардлага, бүрдлийг бүрэн хангасан гэж үзвэл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Өрийн удирдлагын тухай хуулийн 35.7-д заасан эрсдэлийн үнэлгээг хийнэ.

4.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрсдэлийн үнэлгээ хийхдээ хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын дэмжлэг, эсхүл зөвлөх үйлчилгээг авч болно.

4.3.Эрсдэлийн үнэлгээ хийхдээ хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын дэмжлэг, эсхүл зөвлөх үйлчилгээ авах эсэхийг эрсдэлийн үнэлгээ хийх шийдвэр гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

4.4.Зөвлөх үйлчилгээ авах тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хугацаатай уялдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 5.1-д заасан хугацааг сунгаж болно. Энэ тохиолдолд зөвлөх үйлчилгээний зардлыг төсөвт тусгах арга хэмжээ авна.

4.5.Эрсдэлийн үнэлгээ хийхдээ хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын дэмжлэг, эсхүл зөвлөх үйлчилгээ авах тохиолдолд тухайн байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд гэрээнд энэ журмын 3.4-т заасан мэдээллийн нууцыг хадгалах, гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүргийг тусгана.

4.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаа гаргуулагчаас ирүүлсэн баримт бичигт үндэслэн холбогдох хууль болон энэ журамд заасны дагуу дор дурдсан төрлийн эрсдэлийн үнэлгээ хийнэ:

4.6.1.баталгаа гаргуулагч этгээдийн эрсдэлийн үнэлгээ;

4.6.2.тухайн төсөл, арга хэмжээний эрсдэлийн үнэлгээ.

4.7.Энэ журмын 4.6-д заасан эрсдэлийн үнэлгээ хийхдээ дараахь нөхцөл, шалгууруудыг харгалзан үзнэ:

- 4.7.1. баталгааны нөхцөл;
  - 4.7.2. зээллэгийн нөхцөл, түүнийг эргүүлэн төлөх төлөвлөгөө;
  - 4.7.3. төсөл, арга хэмжээний үр ашиг, өгөөж, эргэн төлөгдөх чадвар, хэрэгжих үндэслэл;
  - 4.7.4. зээлжих зэрэглэл тогтоодог байгууллагаас өгсөн үнэлгээ;
  - 4.7.5. бусад этгээдэд барьцаалсан хөрөнгө, баталгааны хүрээнд барьцаалах хөрөнгө;
  - 4.7.6. санхүүгийн шинжилгээ;
  - 4.7.7. Энэ журмын 3.1.5-д заасан хөндлөнгийн хууль зүйн болон санхүүгийн шинжилгээний дүгнэлт;
  - 4.7.8. баталгаа гаргуулагч этгээдэд учирч болох санхүүгийн, үйл ажиллагааны, зах зээлийн эрсдэл, болзошгүй өр төлбөрийн эрсдэл;
  - 4.7.9. баталгаа гаргуулагч этгээдийн хөрөнгийн удирдлага;
  - 4.7.10. баталгаа гаргуулагч нь дотоодын арилжааны банк бол:
    - 4.7.10.1. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт;
    - 4.7.10.2. Монголбанкинд хүргүүлдэг банкны тайлангийн үзүүлэлт;
    - 4.7.10.3. Монголбанкны хяналт, шалгалтын тайлан, стресс тестийн дүгнэлт.
  - 4.7.11. энэ журмын 2.3.2-т заасан шаардлага.
- 4.8. Энэ журмын 4.6-д заасан эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг дараахь 5 түвшинд хуваана:
- 4.8.1. маш өндөр эрсдэлтэй;
  - 4.8.2. өндөр эрсдэлтэй;
  - 4.8.3. дундаж эрсдэлтэй;
  - 4.8.4. бага эрсдэлтэй;
  - 4.8.5. маш бага эрсдэлтэй.



4.9. Эрсдэлийн үнэлгээгээр баталгаа гаргуулагчийг, эсхүл төсөл, арга хэмжээний үнэлгээг маш өндөр эрсдэлтэй, эсхүл өндөр эрсдэлтэй гэж дүгнэсэн нь тухайн баталгааг гаргахгүй байх үндэслэл болно.

4.10. Энэ журмын 3.1-д заасан баримт бичгийн үнэн зөв эсэхийг тодорхойлолт, дүгнэлт гаргасан тухайн байгууллага, баталгаа гаргуулагч бүрэн хариуцна.

4.11. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрсдэлийн үнэлгээ хийхдээ тухайн баримт бичгийн үнэн зөв эсэхийг тодруулах зорилгоор холбогдох байгууллагаас тодруулга авч болно.

4.12. Энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, худал мэдүүлсэн, баталгаа гаргагчийг төөрөгдүүлсэн гэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үзсэн бол уг асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шалгуулахаар эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

4.13. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрсдэлийн үнэлгээ хийсний үндсэн дээр төсөл, арга хэмжээ, баталгаа гаргуулагчийг эрсдэлтэй гэж дүгнэсэн тохиолдолд Засгийн газрын өрийн баталгаа гаргах боломжгүй тухай үндэслэл бүхий мэдэгдлийг хүсэлт гаргасан хуулийн этгээдэд хүргүүлнэ.

4.14. Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч нь энэ журмын 2.3.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд баталгаа гаргуулагчийг өндөр эрсдэлтэй гэж үзэх үндэслэл үүснэ.

4.15. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь баталгаа гаргуулагчийн зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх чадвар, төсөвт үүсэж болзошгүй эрсдэлийг судлах зорилгоор жил бүр эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэнэ.

4.16. Энэ журмын 4.8-д заасан эрсдэлийн түвшнийг тогтоохдоо төслийн “эрсдэлтэй” гэж үзсэн зах зээлийн хувьсагч хүчин зүйлсийн хувьд төслийн санхүүгийн мөнгөн урсгалыг олон хувилбараар боловсруулж, харьцуулан шинжлэх ба холбогдох санхүүгийн аргачлал бүхий зааврыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тав. Засгийн газрын өрийн баталгаа гаргах  
асуудлыг шийдвэрлэх

5.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журамд заасан аргачлалын дагуу баталгаа гаргуулагчид

эрсдэлийн үнэлгээ хийсний үндсэн дээр Засгийн газрын өрийн баталгаа гаргах боломжтой эсэх талаарх дүгнэлтийг өрийн баталгаа гаргуулах тухай энэ журмын 3.1-д заасан албан хүсэлтийг хүлээн авснаас хойш хуанлийн 45 хоногийн дотор гаргана.

5.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хийсэн эрсдэлийн үнэлгээнд хөндлөнгийн аудит хийлгэх зорилгоор тухай бүр төрийн аудитын байгууллагад хүргүүлж, дүгнэлт, зөвлөмж гаргуулна.

5.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын өрийн баталгаа гаргах боломжгүй гэж шийдвэрлэснээс бусад тохиолдолд эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг холбогдох санал, шаардлагатай бусад мэдээллийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.

5.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн баталгааны гэрээ болон авлага барагдуулах гэрээ, баталгаа гаргахтай холбогдох шаардлагатай бусад гэрээний төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хууль зүйн дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлж, эцэслэн шийдвэрлүүлнэ.

5.5.Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай шийдвэр нь Өрийн удирдлагын тухай хуулийн 33.7-д заасны дагуу болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд байна.

5.6.Засгийн газар хэлэлцээд, тухайн зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэсэн тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаа гаргуулагчид нэн даруй мэдэгдэж, Засгийн газрын өрийн баталгааны болон авлага барагдуулах гэрээ, баталгаа гаргахтай холбогдох шаардлагатай бусад гэрээ байгуулах ажлыг эхлүүлнэ.

5.7.Засгийн газрын өрийн баталгааны гэрээ, авлага барагдуулах гэрээний нөхцөл нь Засгийн газрын баталсан маягтын дагуу байх бөгөөд энэ журамд зааснаас зарчмын зөрүүгүй нэмэлт зүйл, заалтыг гэрээний төсөлд тусгаж болно.

5.8.Засгийн газар өрийн баталгаа гаргахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай шийдвэрийг авснаас хойш санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаа гаргуулагчид ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.



5.9.Энэ журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу тооцсон Засгийн газрын өрийн баталгааны шимтгэлийг баталгаа гаргуулагч энэ журмын 8.1-д заасан дансанд шилжүүлнэ.

5.10.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй тохиолдолд дараагийн хөтөлбөрт тусгуулах саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр хариуцсан байгууллагад хүргүүлж болно.

### Зургаа.Засгийн газрын өрийн баталгааны гэрээ

6.1.Засгийн газрын өрийн баталгааны гэрээ (цаашид “баталгааны гэрээ” гэх)-г байгуулахдаа Өрийн удирдлагын тухай хуулийн 35.9 болон 35.10-т заасныг удирдлага болгоно.

6.2.Баталгааны гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаарх хууль зүйн дүгнэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хүсэлтийг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

6.3.Баталгааны гэрээнд дараахь зүйлийг заавал тусгана:

6.3.1.гэрээнд хэрэглэгдэх хууль тогтоомж, эрх зүйн акт, талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлага;

6.3.2.Засгийн газрын өрийн баталгаа нь тухайн зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс бусад төлбөрийг хамаарахгүй байх тухай;

6.3.3.баталгаа гаргуулагч нь Засгийн газрын өрийн баталгааны шимтгэлийг Засгийн газрын өрийн баталгааны дансанд шилжүүлж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай авлага барагдуулах гэрээ байгуулснаар баталгааны гэрээ нь хүчин төгөлдөр болох тухай;

6.3.4.баталгаа гаргуулагч зээллэгийн эргэн төлөлтийг гүйцэтгэх чадваргүй болсон талаарх мэдэгдлийг төрийн аудитын байгууллагын дүгнэлтийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснээс хойш 30 хоногийн дотор зээлдүүлэгч байгууллага нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад баталгааны төлбөрийн нэхэмжлэхийг хүргүүлэх үүрэгтэй тухай;

6.3.5.Засгийн газрын өрийн баталгааны үүрэг нь баталгааны гэрээний үүрэг биелэгдсэнээр, эсхүл гэрээнд заасан бусад үндэслэлээр дуусгавар болох тухай;

6.3.6.Өрийн удирдлагын тухай хуулийн 35.2-т заасан Засгийн газрын өрийн баталгаа гаргах хувь хэмжээ;

6.3.7.маргаан шийдвэрлэх журам;

6.3.8.Өрийн удирдлагын тухай хуулийн 35.3-т заасны дагуу зээллэгтэй тэнцүү хэмжээний Засгийн газрын үнэт цаас барьцаалах замаар Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах тохиолдолд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн зөрүүнээс үүсэх эрсдэлийг баталгаа гаргуулагч хариуцах тухай;

6.3.9.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан, хугацааг сунгасан тохиолдолд уг нэмэлт, өөрчлөлт болон сунгасан гэрээнд Засгийн газрын өрийн баталгаа хамаарахгүй тухай.

6.4.Баталгааны гэрээнд дараахь зүйлийн талаар тусгахыг хориглоно:

6.4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт буй эсэхээс үл хамааран аливаа биет болон биет бус хөрөнгийг хураах, битүүмжлэх, худалдах, эсхүл хураах, битүүмжлэх, худалдах боломж бүхий нөхцөл;

6.4.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт буй эсэхээс үл хамааран аливаа биет болон биет бус хөрөнгө, төсвийн орлогыг зээлдүүлэгч, эсхүл аливаа гуравдагч этгээд барьцаалах боломж бүхий нөхцөл.

6.5.Өрийн удирдлагын тухай хуулийн 35.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн баталгаа гаргуулж байгаа тохиолдолд баталгааны гэрээ байгуулагдсан өдөр Монголбанкнаас зарласан мөн өдрийн албан ханшаар тооцсон зээллэгийн хэмжээнээс баталгаа гаргуулагчийн эзэмшиж буй Засгийн газрын үнэт цаасны нэрлэсэн дүн нь багагүй байна.

6.6.Баталгааны гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах тохиолдолд дараахь журмыг мөрдөнө:

6.6.1.Баталгаа бүхий зээллэгийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах тохиолдолд хуанлийн 30-аас доошгүй хоногийн өмнө баталгаа гаргуулагч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр мэдэгдэнэ;

6.6.2.Зээллэгийн гэрээний хугацааг сунгах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан баталгааг тэрхүү сунгасан болон нэмэлт, өөрчлөлт оруулсан хүрээнд үйлчлэхээр өөрчлөх хүсэлтийг баталгаа гаргуулагч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болно;

6.6.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг хүлээж аваад анх баталгаа гаргах үндэслэл болсон нөхцөл, баталгааны гэрээ, зээллэгийн гол нөхцөл, агуулгыг өөрчлөх бол, эсхүл баталгаа гаргагчид шинээр үүрэг бий болгосон, эрсдэлийн үнэлгээний үзүүлэлт буурсан, Монгол Улсын ашиг сонирхолд үл нийцэх зохицуулалтыг агуулсан тохиолдолд дараахь баримт бичгийн хамт Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлнэ:

6.6.3.1.баталгааны гэрээний хугацааг сунгах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд Засгийн газарт учирч болзошгүй эрсдэлийн талаарх санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлт;

6.6.3.2.баталгаа гаргуулагчаас ирүүлсэн зээллэгийн гэрээний хугацааг сунгах, нөхцөлийг өөрчлөх шалтгаан, зээлийг эргэн төлөх төлөвлөгөө, энэ журмын 3.1.5-3.1.7-д заасан баримт бичиг;

6.6.3.3.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.

6.7.Баталгааны хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд Засгийн газрын баталсан аргачлалын дагуу баталгаа гаргуулагч дахин шимтгэл төлнө.

6.8.Энэ журмын 6.6.3-т заасны дагуу баталгааны хугацааг сунгах зөвшөөрлийг Засгийн газраас олгосны дараа энэ журмын 6.7-д заасан шимтгэлийг баталгаа гаргуулагч Засгийн газрын өрийн баталгааны дансанд шилжүүлж, авлага барагдуулах гэрээнд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулна.

6.9.Баталгааны хугацааг сунгасан тохиолдолд авлага барагдуулах гэрээнд түүнтэй холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулна.

#### Долоо.Авлага барагдуулах гэрээ

7.1.Баталгааны гэрээ байгуулахын зэрэгцээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн авлага барагдуулах гэрээг баталгаа гаргуулагчтай байгуулна.





7.2.Авлага барагдуулах гэрээг баталгааны гэрээтэй нэгэн зэрэг байгуулах бөгөөд Засгийн газар баталгаа гаргуулагчаас аливаа авлагагүй болсноор уг гэрээ дуусгавар болно.

7.3.Авлага барагдуулах гэрээнд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

7.3.1.Засгийн газар баталгаа гаргуулагчийн нэрийн өмнөөс баталгааны гэрээний дагуу төлбөр гүйцэтгэсэн тохиолдолд авлага барагдуулах чиглэлээр авах арга хэмжээний тухай;

7.3.2.ханшийн эрсдэлийг баталгаа гаргуулагч хүлээх тухай;

7.3.3.баталгаа бүхий зээллэгийн хөрөнгийн зарцуулалт болон тус хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газарт тогтмол тайлагнах, хянуулах тухай;

7.3.4.үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээний тухай;

7.3.5.баталгаа гаргуулагчийн өмнөөс баталгаа гаргагч төлбөр төлөхдөө татвар болон бусад ямар нэгэн суутгалгүйгээр шилжүүлсэн бол тухайн шилжүүлсэн төлбөрт ногдох татвар, суутгал бусад төлбөрийг баталгаа гаргуулагч бүрэн төлөх үүрэгтэй талаар;

7.3.6.баталгаа гаргуулагч нь зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөхөөс 30 хоногийн өмнө төлбөрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрсөн дансанд тухайн зээллэгийн валютаар бүрэн байршуулах бөгөөд энэ данснаас баталгаа бүхий зээллэгийн төлбөрийг төлөхөөс өөр зориулалтаар зарцуулахыг хориглох тухай;

7.3.7.маргаан шийдвэрлэх тухай.

7.4.Баталгаа гаргуулагч нь Өрийн удирдлагын тухай хуулийн 35.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах тохиолдолд авлага барагдуулах гэрээнд энэ журмын 7.3-т зааснаас гадна дараахь зүйлийг нэмж тусгана:

7.4.1.зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөр хийгдэх өдрөөс 30 хоногийн өмнөөс баталгаа гаргуулагчийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасны нэрлэсэн дүн нь тухайн өдрийн төгрөгийн албан ханшаар тооцсон зээллэгийн дүнгээс багагүй байх;

7.4.2.энэ журмын 7.4.1-д зааснаас бусад үед баталгаа гаргуулагчийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасны нэрлэсэн дүн нь сар бүрийн эцэст тухайн сарын эцсийн өдрийн албан ханшаар тооцсон зээллэгийн дүнгийн 90 хувиас багагүй байх;

7.4.3.энэ журмын 7.4.1, 7.4.2-т заасан шаардлагыг хангах зорилгоор баталгаа гаргуулагчаас Засгийн газрын үнэт цаасыг тусгаарлан баталгаажуулах буюу барьцаалах, нэмж худалдан авах, үүргээ зөрчсөн тохиолдолд хэрхэн зохицуулах тухай;

7.4.4.баталгаа гаргуулагчийн заавал эзэмших Засгийн газрын үнэт цаасыг дуусгавар болох хугацаагаар багцлан зааж өгөх;

7.4.5.баталгаа гаргуулагчийн заавал эзэмших Засгийн газрын үнэт цаасны хэмжээг хангуулах арга хэмжээний тухай;

7.4.6.баталгааны гэрээ байгуулагдсан өдөр Монголбанкнаас зарласан мөн өдрийн төгрөгийн албан ханшаар тооцсон зээллэгийн хэмжээнээс баталгаа гаргуулагчийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасны нэрлэсэн дүн нь багагүй байх тухай.

7.5.Өрийн удирдлагын тухай хуулийн 33.4-т заасан этгээдийн хийх зээллэгийн 85 хүртэлх хувьд Засгийн газрын өрийн баталгаа гаргах тохиолдолд авлага барагдуулах гэрээнд дараахь зүйлийг нэмж тусгана:

7.5.1.Өрийн удирдлагын тухай хуулийн 37.5-д заасны дагуу Засгийн газар баталгаа гаргуулагчийн нэр дээр авлага үүсгэсэн бол тухайн авлагыг Засгийн газарт эргүүлэн төлөх төлбөрийн хуваарь, нөхцөлийг тогтоох;

7.5.2.энэ журмын 7.5.1-д заасан хуваарь, нөхцөлийг тогтооход баталгаа гаргуулагч цаашид санхүүгийн чадавх, үзүүлэлтээ сайжруулах, авлага, зээллэгийг эргүүлэн төлөх хуваарьт төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, сар бүр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах.

7.6.Баталгаа гаргуулагч нь Өрийн удирдлагын тухай хуулийн 35.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн баталгаа гаргуулж, баталгаа бүхий зээллэгийн нийт хөрөнгөөр Монголбанктэй своп хэлцэлд орсон бол тухайн своп хэлцлийн ханшийг ашиглан энэ журмын 7.4-т заасан шаардлагыг хангуулна.

Найм.Засгийн газрын өрийн баталгааны үүрэгтэй  
холбогдон гарах төлбөрийн үүргийг биелүүлэх

8.1.Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүрэг гүйцэтгэх, үүргийн гүйцэтгэлийг хангахын тулд төсөвт батлагдсан хөрөнгийг хуримтлуулах болон төсөвтэй харилцах төгрөгийн ба ам.долларын тусгай данс (цаашид “тусгай данс” гэх)-ыг холбогдох журмын дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төв төрийн санд нээж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр холбогдох гүйлгээг хийнэ.

8.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Өрийн удирдлагын тухай хуулийн 37.1-д заасны дагуу тусгай данснаас Засгийн газрын өрийн баталгааны үүрэгтэй холбогдон гарах төлбөрийг Засгийн газрын шийдвэрийг үндэслэн төлж барагдуулна.

8.3.Тусгай данснаас Өрийн удирдлагын тухай хуулийн 37.1-д зааснаас бусад зориулалтаар зарцуулалт гаргахыг тухайн жилийн төсвийн хуулиар зохицуулах ба түүнд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

8.4.Тусгай дансанд дараахь эх үүсвэрүүдээс хөрөнгө хуримтлуулна:

8.4.1.энэ журмын дагуу тооцсон, Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагчаас гэрээний дагуу төлсөн шимтгэл;

8.4.2.Өрийн удирдлагын тухай хуулийн 37.5-д заасны дагуу бий болсон авлага барагдуулсан хөрөнгийн эх үүсвэр;

8.4.3.жил бүрийн улсын төсөвт тусгаж баталсан хөрөнгө;

8.4.4.Төсвийн тухай хуулийн 34.1.5, Өрийн удирдлагын тухай хуулийн 40.6-д заасны дагуу Засгийн газрын өрийн баталгааны төлбөл зохих дүнг улсын төсөвт тодотгол хийн татан төвлөрүүлсэн хөрөнгө;

8.5.Энэ журмын 8.4.3-т заасан хөрөнгийг хуримтлуулах шаардлагатай тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусган Засгийн газарт хүргүүлнэ.

8.6.Өрийн удирдлагын тухай хуулийн 37.3-т заасан шийдвэрт үндэслэн баталгаа гаргуулагчийн өмнөөс тусгай данснаас төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд дансны үлдэгдэл хүрэлцэхээргүй бол шаардлагатай нэмэлт хөрөнгийг төсвийн тодотголын төсөлд тусган, Засгийн газарт хүргүүлнэ.

8.7.Энэ журмын 8.6-д заасан хөрөнгийг төсөвт тусгахад дараахь баримт, бичгийг бүрдүүлсэн байна:

8.7.1.Баталгаа гаргуулагчийн үндсэн болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэж чадахгүй болсон тухай мэдэгдэл, түүнийг нотлох баримт, мэдээлэл, төлбөрийн чадварын талаарх Төрийн аудитын газраас ирүүлсэн аудитын тайлан, дүгнэлт;

8.7.2.Холбогдох этгээдээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэх;

8.7.3.Засгийн газрын өрийн баталгааны дагуу баталгаа гаргуулагчийн өмнөөс төлөх төлбөрийн үүргийг гүйцэтгэх талаар Засгийн газрын гаргасан шийдвэр.

8.8.Баталгаа гаргуулагчийн өмнөөс Засгийн газар төлбөрийг гүйцэтгэх болсонтой холбогдуулан баталгаа гаргуулагчийн санхүүгийн байдлыг сайжруулах талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, авлага барагдуулах гэрээний дагуу баталгаа гаргуулагчийн хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх ажлын төлөвлөгөөг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаа гаргуулагчтай хамтран боловсруулж, Засгийн газар шийдвэрлэнэ.

8.9.Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүрэг гүйцэтгэх, үүргийн гүйцэтгэлийг хангах хөрөнгийг хуримтлуулах тусгай дансны хөрөнгийн эх үүсвэрийг захиран зарцуулах болон төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд дараахь үйл ажиллагаа хийгдэнэ:

8.9.1.Баталгаа гаргуулагчаас үндсэн болон хүүгийн төлбөрийг гүйцэтгэж чадахгүй болсон тухай мэдэгдэл ирүүлсэн тохиолдолд энэ журмын 8.7-д заасан баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрдүүлэн судалж, холбогдох шийдвэрийг гаргуулахаар шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлнэ;

8.9.2.Засгийн газрын өрийн баталгааны дагуу төлөх төлбөрийг гүйцэтгэхтэй холбоотой энэ журмын 8.9.1-д заасан шийдвэрийн төсөл нь дараахь хэлбэртэй байна:

8.9.2.1.Төв төрийн сан дахь тусгай дансны үлдэгдэл нь баталгааны гэрээний дагуу баталгаа гаргуулагчийн өмнөөс төлөхөд хүрэлцэхээр бол төлбөрийн үүргийг гүйцэтгэхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд зөвшөөрсөн тухай Засгийн газрын шийдвэрийн төсөл;

8.9.2.2.Төв төрийн сан дахь тусгай дансны үлдэгдэл нь баталгааны гэрээний дагуу баталгаа гаргуулагчийн өмнөөс төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд уг данснаас байгаа хэмжээгээр нь нэн даруй төлж барагдуулахыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд зөвшөөрсөн тухай, үлдэх хэсгийг төсвийн тодотголд тусгах тухай Засгийн газрын шийдвэрийн төсөл.

8.9.3.Баталгааны дагуу төлөх төлбөрийн нийт дүн тусгай дансны үлдэгдлийн дүнгээс хэтрэхгүй тохиолдолд нэхэмжлэхэд заасан хугацааны дотор төлбөрийг энэ журмын 8.9.2.1-д заасан Засгийн газрын шийдвэрийг үндэслэн гүйцэтгэнэ;

8.9.4.Хэрэв тусгай дансны үлдэгдэл нэхэмжлэхэд заасан төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол нэхэмжилсэн дүнгээс тусгай дансанд байгаа үлдэгдлийн хэмжээгээр энэ журмын 8.9.2.2-т заасан Засгийн газрын шийдвэрийг үндэслэн гүйцэтгэж, үлдэх хэсгийг энэ журмын 8.6 дахь хэсэгт заасны дагуу тухайн жилийн төсөвт тусгуулахаар Төсвийн тухай хуулийн 34.1.5-д заасны дагуу төсвийн тодотголын төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлнэ;

8.9.5.Монгол Улсын Их Хурлаас төсвийн тодотголыг баталж тусгай дансанд эх үүсвэрийг төвлөрүүлснээс хойш энэ журмын 8.9.4-т заасан төлбөрийн үлдэгдлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэн даруй гүйцэтгэнэ.

8.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүрэг гүйцэтгэх, үүргийн гүйцэтгэлийг хангах хөрөнгийг хуримтлуулах тусгай дансны зарцуулалтын тайланг төсөвт байгууллагын нэгэн адил Төсвийн тухай хуульд зааснаар тайлагнана.

#### Ес.Үүргийн гүйцэтгэлийг хангуулах

9.1.Засгийн газрын үнэт цаасаар баталгаажуулсан буюу барьцаалснаас бусад тохиолдолд Өрийн удирдлагын тухай хуулийн 33.4-т заасан этгээдэд баталгаа гаргахдаа авлагыг барагдуулах зорилгоор баталгаа гаргуулагчийн тухайн зээллэгтэй тэнцүү хэмжээний үл хөдлөх хөрөнгө, орлого, авлага, хувьцаа, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн бусад хөрөнгийг барьцаалах тухай тусдаа гэрээ байгуулна.

9.2.Засгийн газрын өрийн баталгааны тусгай данснаас баталгаа гаргуулагчийн нэрийн өмнөөс төлбөр гүйцэтгэснээр тухайн баталгаа гаргуулагчийн нэр дээр авлага үүсгэж бүртгэнэ.

9.3.Баталгаа гаргуулагч нь авлага барагдуулах гэрээний үүргийг үл маргах журмаар биелүүлэх, авлагыг төлж барагдуулах үүрэгтэй.

9.4.Баталгаа гаргуулагч нь авлагыг барагдуулах санхүүгийн боломжгүй болсон, эсхүл авлага барагдуулах гэрээг биелүүлэхгүй байх тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль болон гэрээ, энэ журмын 9.1-д заасан барьцааны гэрээний дагуу үүргийн гүйцэтгэлийг энэ журмын 9.3-т заасан хэлбэрээр хангуулна.

#### Арав.Хяналт

10.1.Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

10.2.Энэ журмын 10.1-д заасан хяналтыг хэрэгжүүлэхдээ Засгийн газрын өрийн баталгааны хүрээнд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ тус бүрд тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал эрхэлсэн нэгж нь тэдгээрийн үйл ажиллагаанд холбогдох журамд заасан аргачлалын дагуу, тогтоосон хугацаанд зохих хяналтыг тавьж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

10.3.Тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн баталгааны хүрээнд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнд байнгын хяналт тавих этгээдийг томилон ажиллуулж болно.

10.4.Баталгаа гаргасан зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь журмаар хяналт тавина:

10.4.1.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч нь Засгийн газрын өрийн баталгаа бүхий зээллэгийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, эсхүл хөрөнгийн зарцуулалтын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн танилцуулах;

10.4.2.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч нь улирал бүрийн санхүүгийн тайланг дараа хоёр улирлын мөнгөн хөрөнгийн төсөөллийн хамт тайлант улирлын дараагийн улирлын эхний сарын 15-ны

өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн танилцуулах;

10.4.3.Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч нь тухайн жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг дараа жилийн эхний улиралд багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд тайлант жилээс хойших нэг жилийн санхүү, мөнгөн хөрөнгийн төсөөллийн хамт танилцуулах;

10.4.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийх бөгөөд эрсдэлийн үнэлгээний үзүүлэлт буурсан, нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд дүгнэлтийг Засгийн газарт танилцуулах;

10.4.5.Шаардлагатай гэж үзвэл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл газар дээр нь очиж баталгаа гаргуулагчийн санхүүгийн нөхцөл байдал болон хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу хяналт тавих, санхүүгийн хяналт шалгалт явуулж болно;

10.4.6.Баталгаа гаргуулагч нь Засгийн газрын өрийн баталгаа бүхий зээлийн ашиглалт гарах, үнэт цаас арилжаалах, үндсэн болон хүүгийн төлбөр, бусад төлбөр, хураамж төлөгдөх тухай бүр ажлын 3 хоногт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

10.5.Засгийн газрын өрийн баталгааны үйл явцад хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь баталгаа гаргуулагчаас шаардлагатай гэж үзсэн мэдээллийг тухай бүр шаардах, гаргуулан авах эрхтэй.

10.6.Энэ журмын 10.5-д заасан мэдээллийн нууцыг энэ журмын 3.2-т заасны дагуу нууцлах үүрэгтэй.

#### Арван нэг.Бусад

11.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11.2.Засгийн газрын өрийн баталгааны холбогдолтой мэдээллийг олон нийтэд мэдээлэх, ил тод байдлыг хангах, тайлагнахдаа Өрийн удирдлагын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийг мөрдлөг болгоно.

---oOo---

Засгийн газрын 2021 оны 210 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

## ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГААНЫ ДАГУУ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Нэг.Засгийн газрын өрийн баталгааны гэрээний  
нийтлэг үндэслэл

1.1.Засгийн газрын өрийн баталгааны гэрээ (цаашид “гэрээ” гэх)-г нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн (цаашид “баталгаа гаргагч” гэх), нөгөө талаас (Баталгаа гаргуулагчийн нэр) (цаашид “баталгаа гаргуулагч” гэх), (Зээлдүүлэгчийн нэр/Итгэмжлэгдсэн этгээдийн нэр) (цаашид “зээлдүүлэгч”/“итгэмжлэгдсэн этгээд” гэх)-ны хооронд 20\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-ны өдөр дараахь нөхцөлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

Тайлбар: Шаардлагатай тохиолдолд энэ гэрээнд бусад этгээдийг оролцуулж болно.

1.1.1.Баталгаа гаргуулагч (зээлдүүлэгчийн нэр/олон улсын зах зээл)-аас нийт (зээллэгийн дүн, валют, хүү, хугацаа) зээллэг хийхээр шийдвэрлэсэн;

1.1.2.Дээрх 1.1.1-д заасан үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор баталгаа гаргуулагчийн хүсэлт дээр үндэслэн баталгаа гаргагч нь Засгийн газрын 20\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-ны өдрийн \_\_\_\_ (Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг шийдвэрлэсэн тогтоолын дугаар) дугаар тогтоолын хүрээнд баталгаа гаргуулагчийн (зээллэгийн дүн, валютын нэгж) хүртэлх зээллэгийн (цаашид “баталгаажсан төлбөр” гэх) 100 хүртэлх хувийн/85 хүртэлх хувийн дүн ба түүнд ноогдох хүүгийн төлбөрт баталгаа гаргахаар шийдвэрлэсэн;

1.1.3.Энэ гэрээ нь баталгаа гаргуулагч Засгийн газрын өрийн баталгааны шимтгэлийг Засгийн газрын өрийн баталгааны тусгай дансанд шилжүүлж, баталгаа гаргагчтай Авлага барагдуулах гэрээ байгуулснаар хүчин төгөлдөр болно;

1.1.4.Энэ гэрээ нь байгуулагдсан өдрөөс хойш хуанлийн 186 хоногийн дотор хүчин төгөлдөр болоогүй тохиолдолд холбогдох бусад гэрээний хамт дуусгавар болсонд тооцогдоно;

1.1.5.Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь баталгаа гаргуулагчийн үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг төлөөлж, Итгэмжлэлийн гэрээний дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрсөн;



Тайлбар: Дээрх 1.1.5 дахь заалтыг баталгаа гаргуулагч үнэт цаас гаргах тохиолдолд оруулах бөгөөд гэрээнд итгэмжлэгдсэн этгээд оролцохгүй тохиолдолд итгэмжлэгдсэн этгээдтэй холбоотой заалтыг хасна.

1.1.6.Энэ гэрээний хүрээнд баталгаа гаргуулагчийн нэрийн өмнөөс баталгаа гаргагч баталгаажсан төлбөрийг гүйцэтгэсэн бол тэрхүү төлбөрийг нөхөн төлөхийг баталгаа гаргуулагч зөвшөөрч Авлага барагдуулах гэрээ, Хөрөнгө барьцаалах гэрээг тус тус байгуулна;

Тайлбар: Энэ гэрээний загварт Засгийн газрын өрийн баталгааны ерөнхий нөхцөлийг багтаасан бөгөөд Өрийн удирдлагын тухай хууль, Иргэний хууль, “Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавих шаардлага, авлага барагдуулах журам”-д заасны дагуу холбогдох бусад заалтыг нэмж тусгаж болно.

1.1.7.Баталгаа гаргуулагчийн эзэмшиж байгаа Засгийн газрын үнэт цаасны дуусгавар болох хугацаа нь баталгааны хугацаанаас өмнө дуусгавар болох нөхцөл байдал үүсэх тохиолдолд холбогдох харилцааг уг баталгааны авлага барагдуулах гэрээгээр зохицуулна.

Тайлбар: Өрийн удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт зааснаар баталгаа гаргуулж байгаа тохиолдолд дээрх заалтыг тусгана.

Хоёр.Засгийн газрын өрийн баталгааны  
ерөнхий нөхцөлүүд

2.1.Баталгаа гаргагч нь баталгаа гаргуулагч (зээлдүүлэгчийн нэр)-аас авах (зээллэгийн дүн, валютыг оруулах) зээллэгт 100 хувь хүртэлх/85 хувь хүртэлх баталгааг үл маргалдах журмаар гаргана.

2.2.Засгийн газрын өрийн баталгаа нь баталгаа гаргуулагчийн зээллэгийн зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрт хамаарна.

2.3.Засгийн газрын өрийн баталгааны хүчинтэй байх хугацаа нь 20\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-ны өдөр, эсхүл гэрээний үүрэг бүрэн биелснээр дуусгавар болно.

2.4.Баталгаа гаргуулагч нь зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг товлосон хугацаандаа төлөх боломжгүй болсон тохиолдолд энэ гэрээнд заасан журмын дагуу баталгаа гаргагч зээлдүүлэгчид төлнө.

2.5.Баталгаа гаргуулагч өөрийн эрхлэх үйл ажиллагаанаас эсхүл төрийн байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрээс үүдэн төлбөрийн

чадваргүй болох, бүтцийн өөрчлөлтөд орох, эсхүл зээллэгийн төлбөрийг гүйцэтгэх боломжгүй болох, дампуурах аливаа нөхцөл байдал үүсэх нь энэ гэрээгээр баталгаа гаргагчийн зээлдүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэг дуусгавар болох, хүчингүй болох үндэслэл болохгүй.

2.6. Баталгаа гаргагч нь энэ гэрээний хүрээнд хүлээсэн баталгааны үүргийг цуцлах, эсхүл шилжүүлэхгүй.

2.7. Баталгаа гаргагч нь энэ гэрээний хүрээнд хүлээсэн баталгааны үүргээ хэрэгжүүлж баталгаа гаргуулагчийн өмнөөс баталгаажсан төлбөрийг гүйцэтгэхдээ зээлдүүлэгчийн нэхэмжлэх, баталгаа гаргуулагчийн хүсэлт, Төрийн аудитын газрын дүгнэлтийг үндэслэл болгоно.

2.8. Зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тухай болон Төрийн аудитын газрын дүгнэлтийг цаг тухайд нь гаргуулж, зээллэгийн төлбөрийг баталгаа гаргагч товлосон хугацаанд гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх үүргийг баталгаа гаргуулагч хүлээнэ.

2.9. Баталгаа гаргагчийн гэрээний хүрээнд хүлээсэн төлбөрийн үүрэг нь баталгаа гаргагчийн бусад гадаад өр, төлбөртэй ижил зэрэглэлтэй байна.

2.10. Энэ гэрээ болон түүнийг дагалдан байгуулах бусад гэрээнд оролцож байгаа талуудын эрх, үүрэг, холбогдох бусад асуудлыг тодорхойлохдоо Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэглэх бөгөөд мөн хуульд заасны дагуу тэдгээрийг тайлбарлана.

2.11. Энэ гэрээний харилцаанд үүсэх аливаа маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Тайлбар: Дээрх 2.11 дэх заалтад “Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулах журам”-ын 6.2-т заасан хууль зүйн дүгнэлтийг гаргуулахад хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн өөр шүүхийг тусгаж болно.

Тайлбар: Баталгаа гаргуулагч нь зээл авах, үнэт цаас гаргахаас хамаарч энэ загварт хэрэглэсэн “зээллэг” гэсэн нэр томъёог өөрчилнө.

---oO---

Засгийн газрын 2021 оны 210 дугаар  
тогтоолын 3 дугаар хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГААНЫ АВЛАГА  
БАРАГДУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

1.Засгийн газрын 20.. оны \_\_ дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар “...” тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулах журам”, Засгийн газрын 20\_\_ оны \_\_ дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар “...” тогтоолыг тус тус үндэслэн (баталгаа гаргуулагч)-д Засгийн газрын өрийн баталгаа гаргасантай холбогдуулан үүсэх эрсдэлээс сэргийлэх, өрийн баталгааны гэрээний дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Засгийн газар) баталгаа гаргуулагчийн өмнөөс төлбөр төлсөн тохиолдолд түүнийг нөхөн төлүүлэх, авлага барагдуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нэг талаас санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүнийг төлөөлж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн \_\_\_\_\_ (цаашид “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэх), нөгөө талаас (баталгаа гаргуулагч), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал \_\_\_\_\_ (цаашид “баталгаа гаргуулагч” гэх) нар (хамтад нь “Талууд” гэх) дараахь нөхцөлийг харилцан тохиролцож энэ гэрээг байгуулав.

Тайлбар: Шаардлагатай тохиолдолд энэ гэрээнд бусад этгээдийг оролцуулж болно.

1.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь баталгаа гаргуулагчийн \_\_ хугацаатай, \_\_ хүүтэй \_\_\_\_\_ (зээллэгийн дүн, валют)-ын зээллэгт Засгийн газрын өрийн баталгаа (цаашид “баталгаа” гэх) гаргахаар шийдвэрлэсэн.

1.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын 20\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-ны өдрийн \_\_ (Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг шийдвэрлэсэн тогтоолын дугаар) дугаар тогтоолыг үндэслэн баталгаа гаргуулагчийн (зээллэгийн дүн, валютын нэгж) хүртэлх зээллэгийн 100 хүртэлх хувийн/85 хүртэлх хувь ба түүнд ноогдох хүүгийн төлбөрт баталгаа гаргахаар шийдвэрлэсэн.

Тайлбар: Өрийн удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасан нөхцөлөөр болон 100 хувь төрийн өмчит аж ахуйн нэгж, Хөгжлийн банкинд баталгаа гаргахаас бусад тохиолдолд дараахь 1.3 дахь заалтыг тусгана.

1.3.Баталгаа гаргуулагч нь Засгийн газрын өрийн баталгаа бүхий зээллэгийн хэмжээнээс багагүй дүнгээр өөрийн хувьцаа, биет болон биет бус хөрөнгө, орлогыг барьцаа болгохыг зөвшөөрч Хөрөнгө барьцаалах гэрээг байгуулсан.

Тайлбар: Өрийн удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасан нөхцөлөөр баталгаа гаргах тохиолдолд дараахь 1.3 дахь заалтыг тусгана.

1.4.Баталгаа гаргахаас өмнө баталгаа гаргуулагч гадаад зээллэгтэйгээ Монголбанкны Баталгаа гаргах өдрийн зарласан ханшаар бодсон дүнтэй тэнцүү хэмжээгээр Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГҮЦ)-ыг худалдаж авч баталгаажуулсан буюу барьцаалуулсан байна.

Тайлбар: Энэ гэрээний загварт Засгийн газрын өрийн баталгааны ерөнхий нөхцөлийг багтаасан бөгөөд “Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавих шаардлага, авлага барагдуулах журам”-д заасны дагуу холбогдох бусад заалтыг нэмж тусгаж болно.

1.5.Засгийн газрын өрийн баталгаа гаргасантай холбогдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь баталгаа гаргуулагчийн үйл ажиллагаа, түүний эрсдэл, санхүүгийн байдал, баталгаа бүхий зээллэгийн хөрөнгийн зарцуулалт, түүний эргэн төлөлтийн талаар тогтмол хяналт тавихыг баталгаа гаргуулагч хүлээн зөвшөөрч, холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн хүргүүлэх үүргийг хүлээсэн.

1.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь (Засгийн газар) нь баталгаа гаргуулагчийн өмнөөс аливаа төлбөрийг зээлдүүлэгчид гүйцэтгэсэн тохиолдолд тэрхүү төлбөрийг нөхөн төлөх арга хэмжээг энэ Гэрээнд заасны дагуу гүйцэтгэх бөгөөд үүнийг Баталгаа гаргуулагч үл маргалдах журмаар биелүүлэхээ хүлээн зөвшөөрсөн.

1.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн баталгааны гэрээ болон энэ гэрээний хүрээнд баталгаа гаргуулагчаас аливаа авлагагүй болсон үед энэ гэрээ дуусгавар болно.

1.8.Баталгаа гаргуулагч нь энэ гэрээний хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзахгүй, түүнийг бусдад шилжүүлэхгүй бөгөөд энэ нь баталгаа гаргуулагч төлбөрийн чадваргүй болсон, бүтцийн өөрчлөлтөд орсон, дампуурснаас үл хамаарч хүчинтэй хэвээр байна.



1.9. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь баталгаа гаргуулагчийн өмнөөс аливаа төлбөрийг зээлдүүлэгчид гүйцэтгэсэн бол авлага барагдуулах арга хэмжээг авах эрх үүссэнд тооцох бөгөөд энэ арга хэмжээг өөрийн итгэмжлэгдсэн этгээдээр гүйцэтгүүлж болно. Баталгаа гаргуулагч нь тэрхүү итгэмжлэгдсэн этгээдийн авлага барагдуулах арга хэмжээ, шийдвэрийг үл маргах журмаар биелүүлэх үүрэгтэй.

1.10. Энэ гэрээ болон түүнийг дагалдан байгуулах бусад гэрээнд оролцож байгаа талуудын эрх, үүрэг, холбогдох бусад асуудлыг тодорхойлохдоо Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэглэх бөгөөд мөн хуульд заасны дагуу тэдгээрийг тайлбарлана.

1.11. Энэ гэрээний харилцаанд үүсэх аливаа маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

---o0o---

Засгийн газрын 2021 оны 210 дугаар  
тогтоолын 4 дүгээр хавсралт

## ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА ГАРГУУЛАГЧИЙН ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ДҮНГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын өрийн баталгаа гаргуулагч нь Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийн эх үүсвэрээр баталгаа гаргуулах үйлчилгээнд зохих хэмжээний шимтгэл төлөх үүрэг хүлээх бөгөөд шимтгэлийн дүнг тооцох, уг шимтгэлийг Төсвийн тухай хуульд заасан Төв төрийн сан дахь тусгай дансанд төвлөрүүлэхэд энэ аргачлалыг баримтална.

1.2. Баталгаа гаргуулагчаас Засгийн газрын өрийн баталгааны санд төлөх шимтгэлийн дүнг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ аргачлалын дагуу тооцох бөгөөд шимтгэлийг Төрийн сан дахь Засгийн газрын өрийн баталгааны тусгай дансанд төвлөрүүлнэ.

Хоёр.Шимтгэлийн дүнг тооцоход баримтлах  
зарчим, шимтгэл тооцох аргачлал

2.1.Засгийн газрын өрийн баталгааны санд баталгаа гаргуулагчаас төлөх шимтгэлийн дүнг эрсдэлгүй байх, шимтгэл тооцох аргачлал энгийн, ойлгомжтой байх үндсэн зарчмыг баримтлан дараахь байдлаар тооцно:

2.1.1.баталгаа гаргуулагч этгээд болон төсөл, арга хэмжээнд хийсэн эрсдэлийн үнэлгээг тооцоололд ашиглах;

2.1.2.шимтгэлийн дүнг төгрөгөөр илэрхийлэхдээ Засгийн газрын өрийн баталгааны гэрээ байгуулагдсан болон гэрээ сунгагдсан өдрийн Монголбанкнаас зарласан албан ханшийг ашиглах.

2.2.Шимтгэлийг баталгаа гаргуулагч этгээд Засгийн газрын үнэт цаасаар баталгаажуулсан буюу барьцаалж байгаа эсэхээс хамааран энэ аргачлалын 2.3 эсхүл, 2.7-д заасны дагуу тооцно.

2.3.Баталгаа гаргуулагч нь Засгийн газрын үнэт цаас баталгаажуулах буюу барьцаалахгүйгээр баталгаа гаргуулах тохиолдолд шимтгэлийн хэмжээг тооцохдоо суурь шимтгэл дээр баталгаа гаргуулагч этгээд болон хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр тогтоосон хувийн аль өндөр хувь хэмжээг нэмэх ба дараахь байдлаар томъёолно:

$$Fg = A * (r + i)$$

$Fg$  – Баталгаа гаргуулагчаас Засгийн газрын өрийн баталгааны санд төлөх шимтгэлийн нийт дүн;

$A$  - Засгийн газрын гаргах өрийн баталгааны хэмжээ;

$r$  – Энэ аргачлалын 2.4-т заасан суурь шимтгэлийн хувь хэмжээ;

$i$  – Энэ аргачлалын 2.5-д заасан баталгаа гаргуулагч этгээдийн эрсдэлийн үнэлгээнд харгалзах хувь болон 2.6-д заасан төсөл, арга хэмжээний эрсдэлийн үнэлгээнд харгалзах хувийн аль өндөр хувь хэмжээ.

2.4.Суурь шимтгэлийн хувь хэмжээ нь тогтмол бөгөөд 0.5 хувь байна.

2.5.Баталгаа гаргуулагч этгээдийн эрсдэлийн үнэлгээнд харгалзах хувь хэмжээг дараахь байдлаар тогтооно:

2.5.1. маш өндөр эрсдэлтэй – 2.25 хувь;

2.5.2. өндөр эрсдэлтэй – 1.5 хувь;

2.5.3. дундаж эрсдэлтэй – 0.75 хувь;

2.5.4. бага эрсдэлтэй – 0.5 хувь;

2.5.5. маш бага эрсдэлтэй – 0.25 хувь.

2.6. Баталгаа гаргуулагч этгээдийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эрсдэлийн үнэлгээнд харгалзах хувь хэмжээг дараахь байдлаар тогтооно:

2.6.1. маш өндөр эрсдэлтэй – 2.25 хувь;

2.6.2. өндөр эрсдэлтэй – 1.5 хувь;

2.6.3. дундаж эрсдэлтэй – 0.75 хувь;

2.6.4. бага эрсдэлтэй – 0.5 хувь;

2.6.5. маш бага эрсдэлтэй – 0.25 хувь.

2.7. Баталгаа гаргуулагч нь Засгийн газрын үнэт цаасаар баталгаажсан буюу барьцаалж баталгаа гаргуулах тохиолдолд шимтгэлийн хэмжээг тооцохдоо Засгийн газрын баталгаа гаргуулагч этгээд болон хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр тогтоосон хувийн аль өндөр хувь хэмжээг Засгийн газрын баталгааны дүнгээр үржүүлэх бөгөөд дараахь байдлаар томьёолно:

$$Fg = A * R$$

$Fg$  – Баталгаа гаргуулагчаас Засгийн газрын өрийн баталгааны санд төлөх шимтгэлийн нийт дүн;

$A$  – Засгийн газрын гаргах өрийн баталгааны хэмжээ;

$R$  – Энэ аргачлалын 2.8-д заасан баталгаа гаргуулагч этгээдийн эрсдэлийн үнэлгээнд харгалзах хувь болон 2.9-д заасан төсөл, арга хэмжээний эрсдэлийн үнэлгээнд харгалзах хувийн аль өндөр хувь хэмжээ. Хэрэв баталгаа гаргуулагчийн хийх зээллэгийн төсөл, арга хэмжээг тодорхойлох боломжгүй тохиолдолд энэ аргачлалын 2.8-д заасан баталгаа гаргуулагч этгээдийн эрсдэлийн үнэлгээнд харгалзах хувь хэмжээ байна.



2.8.Баталгаа гаргуулагч этгээдийн эрсдэлийн үнэлгээнд харгалзах хувь хэмжээг дараахь байдлаар тогтооно:

2.8.1.маш өндөр эрсдэлтэй – 10.0 хувь;

2.8.2.өндөр эрсдэлтэй – 8.0 хувь;

2.8.3.дундаж эрсдэлтэй – 3.0 хувь;

2.8.4.бага эрсдэлтэй – 2.0 хувь;

2.8.5.маш бага эрсдэлтэй – 1.5 хувь.

2.9.Баталгаа гаргуулагч этгээдийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эрсдэлийн үнэлгээнд харгалзах хувь хэмжээг дараахь байдлаар тогтооно:

2.9.1.маш өндөр эрсдэлтэй – 10.0 хувь;

2.9.2.өндөр эрсдэлтэй – 8.0 хувь;

2.9.3.дундаж эрсдэлтэй – 3.0 хувь;

2.9.4.бага эрсдэлтэй – 2.0 хувь;

2.9.5.маш бага эрсдэлтэй – 1.5 хувь.

Гурав.Шимтгэл тооцох, Засгийн газрын өрийн  
баталгааны санд төвлөрүүлэх

3.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монголбанкны зарласан албан ханшид үндэслэн Засгийн газрын өрийн баталгааны санд төвлөрүүлбэл зохих шимтгэлийн нийт дүнг энэ аргачлалын дагуу тооцож, нэхэмжлэхийг баталгаа гаргуулагчид Засгийн газрын өрийн баталгааны гэрээнд гарын үсэг зурснаас хойш ажлын 5 хоногийн дотор хүргүүлнэ.

3.2.Баталгаа гаргуулагч нь энэ аргачлалын 3.1-д заасан нэхэмжлэхэд заасан шимтгэлийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Төрийн сангийн Засгийн газрын өрийн баталгааны сангийн тусгай дансанд шилжүүлнэ.

3.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаа гаргуулагчийн шилжүүлсэн төлбөрийн даалгаврыг



баталгаажуулсны үндсэн дээр Засгийн газрын өрийн баталгааны гэрээнд салшгүй хэсэг болгон хавсаргана.

3.4.Засгийн газрын өрийн баталгааны хугацаа сунгагдсан тохиолдолд баталгаа гаргуулагчаас нэмж төлбөл зохих шимтгэлийн дүнг энэ аргачлалын дагуу тооцож, нэхэмжлэхийг 3.1-д заасны дагуу хүргүүлэх бөгөөд тооцоололд гэрээ сунгагдсан өдрийн Монголбанкны зарласан албан ханшийг ашиглана.

#### Дөрөв.Бусад зүйл

4.1.Засгийн газрын өрийн баталгааны санд төлсөн шимтгэлийн баримт нь Засгийн газрын өрийн баталгааны гэрээний салшгүй хэсэг байна.

4.2.Засгийн газрын өрийн баталгааны санд шилжүүлсэн шимтгэлийг баталгаа гаргах зээллэгт энэ аргачлалын дагуу гэрээ сунгагдахаас бусад тохиолдолд зөвхөн нэг удаа тооцож, санд төвлөрүүлэх бөгөөд Засгийн газрын өрийн баталгааны сангаас тус шимтгэлийг баталгаа гаргуулагчид буцаан олгохгүй.

---oOo---

#### Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 200003